

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС БА
БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ХИЛИЙН ГЭРЭЭ

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Дарга ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид нар,

Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийг албан ёсоор тогтоох асуудлыг пролетарийн интернационализмын үзэл санааны үүднээс харилцан хүндэтгэх, тэгш эрх, харилцан ашигтай байх, харилцан ойлголцох, харилцан найр тавих зарчмыг үндэслэн баримталж, нөхөрсөгөөр зөвлөлдөн хэлэлцэж шийдвэрлэх нь хоёр улсын ард түмний ашиг сонирхолд зохицон, хоёр улсын ард түмний ах дүүгийн уламжлалт найрамдал, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэн бэхжүүлэхэд тус дөхөм болно гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлж энэхүү Гэрээг байгуулахаар шийдвэрлээд, өөрсдийн бүрэн эрхт төлөөлөгчөөр:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Даргаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ,

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн дарга ЮМЖААГИЙН ЦЭДЭНБАЛ нарыг тус тус томилов.

Хоёр Талын бүрэн эрхт төлөөлөгчид зохих хэлбэр, журмаар үйлдэгдсэн эрхийн үнэмлэхийг харилцан солилцоод дор дурдсан зүйлүүдийн талаар хэлэлцэн тохиролцов. Үүнд:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Гэрээ байгуулагч Талууд нь тус хоёр улсын хилийн шугамын байршилтын зүг чигийг дор дурдсанаар тодорхойлж зөвшөөрөлцөв. Үүнд:

1. Хятад, Монголын хилийн шугамын баруун үзүүрийн эхлэх цэг болох Монгол Алтайн нуруу /Алтай нуруу/-ны Таван Богд уул/Хүйтэн уул/-ын 4050 тоот өндөрлөгөөс эхлэн хилийн шугам нь Ховд гол ба Хар Эрчис /Эрчис/ голын хоорондох Монгол Алтайн Нуруу /Алтайн нуруу/-ны үндсэн ус хуваагч шугамаар явж 4355 тоот өндөрлөг бүхий Найрамдлын оргил, Постигийн /Битүү Ханасын / даваа,

3622,4 тоот өндөрлөг бүхий Алаг Зэлийн уул, Битүү Ханасын /Мандива/ даваа, Сомын даваа, Тахилт /Тахилга/-ын даваа, 3386,0 тоот өндөрлөг, Хожийн даваа, 3181,2 тоот өндөрлөг, Загастын даваа, Их Түргэний даваа, Сумдайргийн даваа, 8501,4 тоот өндөрлөг, 3943,2 тоот өндөрлөг бүхий Өндөр Хайрхан, Ирмегетэй /Урмогайт/-н даваа, 3326,4 тоот өндөрлөгийг тус тус дайрч 3291,9 тоот өндөрлөгт хүрнэ.

2. 3291,9 тоот өндөрлөгөөс эхлэн хилийн шугам нь зүүн өмнө зүг рүү Ямаатын гол ба Хар Эрчис/Халаэрц гол/голын хоорондох Монгол Алтайн /Алтай/ нуруунаас салбарлан гарсан уулын ус хуваагч шугамаар явж 3161,4 тоот өндөрлөг бүхий Хүйтэн Аршаантын уулыг дайран Урт Булгийн даваанд хүрээд цаашаа Хавцал Булгийн гол/Хүйтэн гол/ ба Урт булгийн голын хоорондох уулын ус хуваагч шугамаар эхлээд зүүн хойшоо, дараа нь зүүн тийшээ эргэж 2295,6 тоот өндөрлөгөөс эгц хойш 0,08 км-д байгаа цэгт хүрч тэндээс голдогч мердианн зүүн хойт зүгт 56 градус 42 минутын хэмжээтэйгээр шулуун шугамаар Ямаатын голд хүрнэ. Цаашаа Ямаатын голын усаар уруудаж мөн голын зам гарсан гарамд хүрээд гармаас мөн голын өмнө талаар явсан замын дагуу явж дахин мөн голд нийлж түүний урсгалаар уруудан Ямаат гол ба Урт Булгийн голын билчирт хүрээд барагцаалбал зүүн урагш уулыг хярдан өгсөж 2761,2 тоот өндөрлөгт хүрнэ. Цаашаа Ямаатын гол ба Шинэ Салаа/Синьжин/голын хоорондох уулын ус хуваагч шугамаар барагцаалбал зүүн урагш уруудан 2225,5 тоот өндөрлөгийг дайран Ёлт гол ба Шинэ Салаа/Синьжин/ голын билчирт хүрээд Ёлт голын усаар уруудаж Ёлт гол ба Бага Түргэний/Их Түргэний голын билчирт хүрнэ. Дараа нь Бага Түргэний /Их Түргэний/ гол ба Их Түргэний /Бага Түргэний/голын хоорондох уулын ус хуваагч шугамаар барагцаалбал зүүн тийш чиглэн явж 3029,5 тоот өндөрлөгийг дайран 3215,1 тоот өндөрлөгт хүрнэ. Цааш Ёлт гол ба Хуримт /Зүүн Салаа/голын хоорондох уулын хуваагч шугамаар барагцаалбал зүүн хойшоо чиглэн явж 3574,6 тоот өндөрлөг бүхий Өвчүүн уул хүрээд тэндээс зүүн зүгээс ялимгүй урагш уулын хяраар явж 3086,8 тоот өндөрлөгийг дайрч цаашаа Шар Хамарын /Батлаша/ гол ба энэ голд баруун талаас урсч орсон нэргүй салаа хоёрын билчрээс доош 0,4 км орчимд байгаа цэгээр Шар Хамарын /Батлаша/ голыг гатааж тэндээс барагцаалбал зүүн хойш уулын хамраар өгсөж Монгол Алтайн /Алтай/ нурууны 3056,8 тоот өндөрлөгт хүрч цаашаа Сагсай гол ба Хуримт /Зүүн Салаа/ голын хоорондох Монгол Алтайн /Алтай/ нурууны

үндсэн ус хуваагч шугамаар барагцаалбал зүүн тийш чиглэн Их/Хуримт/ давааг дайрч зүүн өмнө тийш чиглэн явж 3039,9 тоот өндөрлөгөөс баруун тийш 0,7 км орчимд байгаа уулын хярын нэг цэгт хүрч цааш уулын хярыг дагаж баруун өмнө тийш чиглэн явж 2936,0 тоот өндөрлөгийг дайран цаашаа өмнө зүгээс ялимгүй зүүн тийш чиглэн 1,5 км орчим яваад Бүрхэтүясы Хар / Хэслэг Яа/ голыг гаталж цаашаа уулын хамрыг даган барагцаалбал зүүн урагш чиглэн явж 2998,2 тоот өндөрлөгт хүрнэ.

3. 2998,2 тоот өндөрлөгөөс эхлэн хилийн шугам нь Сагсай гол ба Хар Эрчис /Эрчис/ голын хоорондох Монгол Алтайн/Алтай/ нурууны үндсэн ус хуваагч шугамаар явж Түргэн нуур / Шаужин Суэла/- ын даваа, 3743,1 тоот өндөрлөг, Түргэн даваа, 3626,4 тоот өндөрлөг, 2875,2 тоот өндөрлөг бүхий Хайрт /Мондайчиа/ даваа,3879,4 тоот өндөрлөг,3594,8 тоот өндөрлөгийг тус тус дайрч нэргүй /Хайртын/ даваа хүрч тэндээс зүүн урагш уулын ус хуваагч шугамаар явж 1,6 км орчимд байгаа цэгт хүрч тэндээс баруун урагш эргэж Монгол Алтайн /Алтай/ нуруунаас салбарлаж гарсан уулын хяраар явж 3194,7 тоот өндөрлөгийг дайран цаашаа уулын хамраар уруудаж жижиг нуурын баруун захаар нэргүй голыг гаталж өмнө зүг рүү уулын хамраар өгсөж 3206,0 тоот /3206,8 тоот/ өндөрлөгт хүрч цаашаа уулын хяраар өмнө зүг явж 3199,0 тоот өндөрлөг бүхий нэргүй даваанд хүрнэ. Тэндээс Буянт гол ба Хар Эрчис / Эрчис/ голын хоорондох Монгол Алтайн /Алтай/ нурууны үндсэн ус хуваагч шугамаар явж Элстийн даваа, Чигиртэй даваа, Аршаант даваа,Ганц Модны /Халэгэжагачи/ даваа, 3272,8 тоот өндөрлөгийг тус тус дайран 3869,7 тоот өндөрлөг бүхий Душин уулын оройд хүрнэ.

4. 3869,7 тоот өндөрлөг бүхий Душин уулын оройгоос эхлэн хилийн шугам нь Булган гол ба Чингэл голын хоорондох уул нурууны ус хуваагч шугамаар явж Булган /Дал/ даваа, Хар Нуурын /Мүзэ/ даваа,3622,0 тоот өндөрлөг,Түргэн даваа,Бирх Цахирт /Кумудасу/ даваа,Элстийн даваа,3185,9 тоот өндөрлөг,Их Жаргалангийн/Кайргэн овоо/ даваа,3308,2 тоот өндөрлөг бүхий Асгат Хар уул,3423,2 тоот өндөрлөг бүхий Нүцгэн уул, 3326,0 тоот өндөрлөг,3264,9 тоот өндөрлөг ба 3221 тоот өндөрлөгүүдийг тус тус дайран 3042,8 тоот өндөрлөг бүхий Халзан даваанд хүрнэ.

5. 3042,8 тоот өндөрлөг бүхий Халзан даваанаас эхлэн хилийн шугам нь шулуун шугамаар явж 3127,4 тоот өндөрлөгт хүрч цаашаа

мөн шулуун шугамаар явж 2712,7 тоот өндөрлөг бүхий Газарчийн Шовгор /Газарч ууд/ хүрээд Эрэнцэн уулын оройг чиглэсэн шулуун шугамаар явж Харгайт /Бумбат/-ын голын нэг цэгт хүрнэ.Тэндээс цаашаа энэхүү голын усаар өгсөж мөн гол ба Цагаан Чулуут /Кеке сай/-ын голын билчирт хүрч,Цагаан Чулуут /Кеке Сай/-ын голын усаар өгсөж мөн голын нэг гарамд хүрч цаашаа зүүн урагш чиглэн явсан замаар явж хоёр замын салах цэгт хүрээд баруун талын замаар явж мөн хоёр замын салах цэгт хүрч зүүн талын замаар явж мөн хоёр замын салах цэгт хүрч зүүн талын замаар өмнө тийш уруудан мөн хоёр замын салах цэгт хүрч баруун талын замаар уруудсаар гурван замын салах цэгт хүрч баруун урагшаа шулуун шугамаар 1,6 км орчим явж 1727,0 тоот өндөрлөгт хүрээд цаашаа шулуун шугамаар явж 1496,4 тоот өндөрлөгт хүрч баруун урагш явсан замаар явж хоёр замын салах цэгт хүрч зүүн талын замаар баруун урагш явж 1458,6 тоот өндөрлөг бүхий Хүйсэн Хар толгойн орой /1460,4 тоот өндөрлөг бүхий Булактбай уулын орой/-н хойт зүгээс ялимгүй зүүн тийш 1,1 км орчимд байгаа цэгт хүрч өмнө зүгээс ялимгүй баруун тийш явж Хүйсэн Хар Толгойн /Булактбайн уулын орой/ оройд хүрээд цаашаа шулуун шугамаар баруун зүгээс ялимгүй өмнө тийш чиглэн явж Их Шар булгайр дайрч цаашаа Их Шар булгийн усаар уруудаж Хүйсэн Хар Толгойн орой/Булактбайн уулын орой/-н баруун зүгээс ялимгүй урагш 1,15 км орчимд байгаа цэгт хүрнэ. Цаашаа барагцаалбал зүүн өмнө тийш чиглэн явж 1399,8 тоот өндөрлөгөөс ялимгүй баруун өмнө зүгт 2,1 км орчимд байгаа нэргүй булаг /Сухайтын булаг/-ийн зүүн хойно 0,2 км орчимд байгаа цэгт хүрч цаашаа шулуун шугамаар зүүн урагш явж Булган голыг гаталж 1187,8 тоот өндөрлөг бүхий Сийх Улаан толгой /1192,0 тоот өндөрлөг бүхий Улаан уулын толгой/-д хүрнэ.

6. 1187,8 тоот өндөрлөг бүхий Сийх Улаан толгой/1192,0 тоот өндөрлөг бүхий Улаан уулын толгой/-гоос эхлэн хилийн шугам нь өмнө зүгээс ялимгүй зүүн тийш уулын хяраар явж Гурван Хүүхдийн баруун хойт шовх /1670,0 тоот өндөрлөг/-д хүрч цаашаа шулуун шугамаар явж 1302,6 тоот /1294,0 тоот/ өндөрлөг бүхий Нохой Долоохын Улаан толгойд хүрнэ. Цаашаа шулуун шугамаар явж Дундын овоо /Дүмүба овоо/-нд хүрч цаашаа шулаан шугамаар явж Шаахайтын ус /Дүмбастао булаг/ хүрч дараа нь шулуун шугамаар

явж II87,0 тоот өндөрлөг /II94,0 тоот өндөрлөг/-т хүрээд цаашаа шулуун шугамаар явж Сүүл Хар /I304,0 тоот өндөрлөгөөс зүүн тийш 0,2 км орчимд байгаа цэг /-д хүрээд цаашаа шулуун шугамаар явж I520,2 тоот өндөрлөг бүхий Төмөрийн Хар уул /I527,0 тоот өндөрлөг бүхий Төмөрийн Хар/-д хүрнэ.

7. I520,2 тоот өндөрлөг бүхий Төмөрийн Хар уул/ I527,0 тоот өндөрлөг бүхий Төмөрийн Хар/-аас эхлэн хилийн шугам нь зүүн өмнө зүг рүү шулуун шугамаар явж хоёр замын уулзвар хүрээд цаашаа зүүн урагш явсан замаар явж I682,3 тоот /I690,0 тоот/ өндөрлөгөөс хойш 2,5 км орчимд байгаа цэгт хүрч цаашаа өмнө тийш шулуун шугамаар явж I682,3 тоот /I690,0 тоот/ өндөрлөгт хүрч цаашаа шулуун шугамаар явж 2046,7 тоот /2043,0 тоот/ өндөрлөгт хүрнэ. Цаашаа шулуун шугамаар явж 2540,2 тоот /2543,0 тоот / өндөрлөгт хүрээд тэндээс зүүн зүгээс ялимгүй хойш шулуун шугамаар 2,6 км орчим явж Хужиртын голыг огтлон хоёр/замын уулзвар хүрээд ялимгүй зүүн урагш замаар явж Нарийн Харгайтын /Сяо сун шу гуу/ голыг хөндлөн огтолж цаашаа ялимгүй зүүн урагш замаар явж Нарийн Харгайтын /Сяо сун шу гуу/ голын зүүн талын нэргүй салааны гарамд хүрч цаашаа мөн салааны усаар өгсөж 0,2 км орчимд байгаа нэргүй булагт хүрч тэндээс зүүн урагш чиглэн шулуун шугамаар явж Араат Улаан уул/ 26I4,0 тоот өндөрлөг/-ын баруун зүгээс ялимгүй хойш 0,9 км орчимд байгаа нэргүй булагт хүрнэ. Цаашаа өмнө зүгээс ялимгүй баруун тийш шулуун шугамаар явж 3287,2 тоот /3290,0 тоот/ өндөрлөг бүхий Дүнхгэр буюу Алтан овооноос зүүн хойш 2,5 км орчимд байгаа ургаа хад/3229,0 тоот өндөрлөг/-ыг дайран цаашаа шулуун шугамаар явж 3287,2 тоот өндөрлөг бүхий Дүнхгэр буюу Алтан овоо/ 3290,0 тоот өндөрлөг бүхий Алтан овоо/-нд хүрнэ.

8. 3287,2 тоот өндөрлөг бүхий Дүнхгэр буюу Алтан овоо /3290,0 тоот өндөрлөг бүхий Алтан овоо/-ноос эхлэн хилийн шугам нь зүүн өмнө зүг уулын хяраар 2,1 км орчим явж нэргүй өндөрлөг /3252,0 тоот өндөрлөг/-т хүрч цаашаа барагцаалбал зүүн тийш явж 3035,9 тоот /3025,0 тоот/; 3095,8 тоот /3I02,0 тоот/; 2708,0 тоот /27I7,0 тоот/; 29I2,2 тоот /292I,0 тоот/;2200,1 тоот өндөрлөг бүхий Тугалчийн Хар /2I84,0 тоот өндөрлөг/эдгээр өндөрлөгүүдийг дайран Такыр /Такирбастау/ булгаас зүүн тийш I км орчимд байгаа цэгт хүрээд тэндээс зүүн хойш чиглэн явж

Бага Хавтаг уулын баруун хойт үзүүрийн Улаан хушууны баруун үзүүр /I185 тоот өндөрлөг /-т хүрээд барагцаалбал зүүн урагш Бага Хавтаг уулын Сүүл Харыг дайрч I93I,9 тоот өндөрлөг бүхий Нанжин Хар /I9I9,0 тоот өндөрлөг /-д хүрч тэндээс эхлээд зүүн хойшоо, дараа нь ялимгүй зүүн урагш явж 2029,2 тоот өндөрлөг бүхий Хөх Ааргийн Шовгор /2020,1 тоот өндөрлөг/ -т хүрнэ. Цаашаа шулуун шугамаар явж I773,8 тоот өндөрлөг бүхий Үнгэлцэгийн Бондгор /I787,0 тоот өндөрлөг/-т хүрч цаашаа шулуун шугамаар явж I655,8 тоот /I643,0 тоот/ өндөрлөгт хүрээд шулуун шугамаар явж I765,0 тоот /I770,0 тоот/ өндөрлөгт хүрч цаашаа шулуун шугамаар явж I835,8 тоот өндөрлөгийг дайран дараа нь шулуун шугамаар явж Улаан байшингийн ус булгаас зүүн хойш 0,35 км газарт замыг хөндлөн гарч цаашаа шулуун шугамаар явж 2429,9 тоот /2429,0 тоот/ өндөрлөгөөс баруун хойш 3,9 км орчимд байгаа нэгэн өндөрлөгт хүрч цаашаа шулуун шугамаар явж 2429,9 тоот /2429,0 тоот/ өндөрлөгт хүрнэ. Цаашаа тахиралдсан шугамаар зүүн тийш явж 29I8,5 ба 2597,8 тоот өндөрлөгүүдийг дайрч 2338,7 тоот өндөрлөг /энэ нь 2597,8 тоот өндөрлөгөөс ялимгүй зүүн урагш 6,4 км орчимд байгаа өндөрлөг болно/-т хүрнэ.

9. 2338,7 тоот өндөрлөг/дээр дурдсан өндөрлөг /-өөс эхлэн хилийн шугам нь барагцаалбал зүүн тийшээ чиглэн явж Хөх Өндрийн нурууны I554,3; I426,4; I7+I,6; 2I5I,0; 208I,7 тоот өндөрлөг ба 208I,7 тоот өндөрлөгөөс ялимгүй зүүн урагш 2,5 км орчимд байгаа өндөрлөг / 2036,0 тоот өндөрлөг/-ийг тус тус дайран 2553,7 тоот өндөрлөг бүхий Хөх Өндөр ууланд хүрнэ. Цаашаа барагцаалбал зүүн урагш чиглэн явж Тахийн Шар нуруу /Шарын нуруу/-ны 22I9,3 тоот өндөрлөг, 2430,3 тоот /2430,0 тоот/ өндөрлөг, 253I,7 тоот өндөрлөг бүхий Сандуйжав уул, Тахийн Үзүүр давааг тус тус дайран 2392,0 тоот өндөрлөг бүхий Гох уулд хүрээд цаашаа зүүн өмнө зүг чиглэн Хэрээ нуруу /уул/-н дахь 2063,8 тоот өндөрлөгт хүрч барагцаалбал зүүн урагш явж I4I7,6 тоот өндөрлөг бүхий Махир Хүрэн /I4I7,6 тоот өндөрлөг/-ээс ялимгүй баруун урагш 0,3 км орчимд байгаа уулын оройд хүрээд цаашаа уулын хярыг дагаж зүүн хойш чиглэн явж I4I7,6 тоот өндөрлөгт хүрнэ. Цаашаа шулуун шугамаар явж Говь Хонин усны /Лао Бэ-мяо гэдэг гэсэр сүмийн/ булгийг дайран цаашаа

шулуун сугамаар явж 882,8 тоот өндөрлөг бүхий Боргиот толгой /882,8 тоот өндөрлөг/-д хүрээд барагцаалбал зүүн урагшаа чиглэн явж 991,4 тоот /992,0 тоот/ өндөрлөг, 1007,8 тоот өндөрлөг бүхий Загийн Хүрэн Толгой /1007,0 тоот өндөрлөг/-г тус тус дайран 1034 тоот өндөрлөг бүхий Хавцгайтын Хавцалын өндөр /1036,0 тоот өндөрлөг/-т хүрч цаашаа Сухайтын нурууг дагаж тахиралдсан сугамаар зүүн урагш явж 6,8 км орчимд байгаа цэг /923,0 тоот өндөрлөгөөс зүүн өмнө 1,9 км орчимд байгаа цэг/-т хүрээд цаашаа зүүн зүгээс ялимгүй хойш чиглэн явж 1422,1 тоот өндөрлөгөөс зүүн урагш 4,3 км орчимд байгаа өндөрлөг /1344,0 тоот өндөрлөг /-т хүрч зүүн урагшаа 2 км орчим яваад тэндээс өмнө зүгээс ялимгүй баруун тийш чиглэн явж Сондгой Улаан /1009,0 тоот өндөрлөг /-ыг дайран 804,3 тоот /813,0 тоот/ өндөрлөгийн баруун зүгээс ялимгүй урагш 5,2 км орчимд байгаа сайр дахь цэгт хүрнэ. Цаашаа зүүн зүгээс ялимгүй урагш чиглэн явж 845 тоот өндөрлөгийн өмнө зүгээс ялимгүй зүүн тийш 4,3 км орчимд байгаа цэг/ 809,0 тоот өндөрлөгөөс зүүн урагш 8,6 км орчимд байгаа цэг /-т хүрнэ. Цаашаа шулуун сугамаар явж 651,8 тоот /658,0 тоот /өндөрлөг бүхий Элст Сайрын Ар Улаан толгой хүрээд дараа нь шулуун сугамаар явж 760,7 тоот/ 762,0 тоот/ өндөрлөгт хүрч цаашаа шулуун сугамаар явж 800,3 тоот /792,0 тоот/ өндөрлөгийг дайран дараа нь шулуун сугамаар 706,0 тоот /710,0 тоот/ өндөрлөгт хүрээд шулуун сугамаар явж 745,4 тоот /749,4 тоот / өндөрлөг бүхий Шар Ухаагийн Зүүн Хар толгой хүрч цаашаа шулуун сугамаар явж Нарийн Тооройн булаг /Далийн булаг/-ийг дайран шулуун сугамаар явж 1034,6 тоот өндөрлөг /1044,0 тоот өндөрлөг бүхий Далан Түлэ Таг /-т хүрнэ. Цаашаа шулуун сугамаар явж 1456,6 тоот /1456,0 тоот /өндөрлөг бүхий Талын Малтсийн Өндөр овоог дайран шулуун сугамаар явж 1654,5 тоот /1654,0 тоот/ өндөрлөг бүхий Халхын Баруун өмнө овоо хүрнэ.

10. 1654,5 тоот /1654,0 тоот / өндөрлөг бүхий Халхын баруун өмнө овооноос эхлэн хилийн сугам нь шулуун сугамаар явж 1285,2 тоот өндөрлөгт хүрч цаашаа шулуун сугамаар Наран Сэвстэйн булаг ба монголын хилийн цэргийн заставын байрын хоорондох цэгт хүрч тэндээс шулуун сугамаар явж 1380,6 тоот өндөрлөг бүхий Наран Сэвстэйн Өндөр овоонд хүрч цаашаа 1121,3/ Шалын уул; 1215,8;

II41,3 тоот өндөрлөгүүдийг тус тус шулуун шугамаар дайрч
I2I7,9 тоот өндөрлөг бүхий Догногор овоонд шулуун шугамаар
хүрч мөн шулуун шугамаар I225,4 тоот өндөрлөг бүхий Гурван
Үнэгэд Уулын овоо /Догшин Гурван Өндөр овоо/-нд хүрээд цаа-
шаа шулуун шугамаар явж Адаг Боомын худаг /Хүрэн Боомын
худаг/-т хүрч тэндээс хойш замын дагуу 0,7 км явж их зам
ба ердийн замын салах цэгт хүрч дараа нь шулуун шугамаар явж
I000,5 тоот өндөрлөгт хүрч цаашаа шулуун шугамаар явж
I030 тоот өндөрлөг бүхий Цагаан уул хүрч мөн шулуун шугамаар
I067,8 тоот өндөрлөг /Улаан Цонжийн өндөрлөг /-т хүрээд шу-
луун шугамаар явж II22,6 тоот өндөрлөг бүхий Цагаан Толгойн
овоо /Талын Гүн-нд хүрнэ.

II. II22,6 тоот өндөрлөг бүхий Цагаан толгойн овоо /Талын
Гүн /-ноос эхлэн хилийн шугам нь шулуун шугамаар явж I243,2
тоот өндөрлөг бүхий Элст Хөтлийн овоо /Мааньтын шил/-нд хүрч
Цаашаа шулуун шугамаар явж I337 тоот өндөрлөг бүхий Алаг уул
хүрээд цаашаа шулуун шугамаар явж I273,1 тоот өндөрлөгийн
хойт зүгээс ялимгүй зүүн тийш I,5 км орчимд байгаа цэг /Алаг
Цонж /-т хүрч тэндээсээ шулуун шугамаар явж I344,0 тоот өн-
дөрлөгөөс ялимгүй зүүн урагш I,6 км орчимд байгаа цэг /Сайж/-т
хүрнэ. Цаашаа шулуун шугамаар явж I372 тоот өндөрлөг бүхий
Их Хонгоржийн ууланд хүрээд тэндээс шулуун шугамаар явж I395
тоот өндөрлөг бүхий Хөх морьтын уул хүрнэ. Цаашаа шулуун
шугамаар явж I204 тоот өндөрлөг бүхий Шар толгойн овоо, III17,0
тоот өндөрлөг бүхий Заацын Хар овоо /Дөрөө уул /, I057,9 тоот
өндөрлөг бүхий Амны Бургасны овоог тус тус шулуун шугамаар
дайрч I061 тоот өндөрлөг бүхий Ончийн овоо /Хайхуйгүн /-д хүрнэ.

I2. I061 тоот өндөрлөг бүхий Ончийн овоо /Хайхуйгүн /-ноос
эхлэн хилийн шугам нь шулуун шугамаар явж 880 тоот өндөрлөг
бүхий Хүрэн Босгын овооноос хойш барагцаалбал 2,4 км орчимд
байгаа цэгт хүрнэ. Цаашаа шулуун шугамаар явж 858,3 тоот
өндөрлөгт хүрч мөн шулуун шугамаар явж 855,0 тоот өндөрлөгөөс
ялимгүй баруун урагш 3 км орчимд байгаа хуурай сайрын нэг
цэгт хүрнэ. Цаашаа шулуун шугамаар явж 803,3 тоот өндөрлөгөөс
баруун өмнө 0,7 км орчимд байгаа толгойн орой /793,0 тоот
өндөрлөг/-д хүрч тэндээс шулуун шугамаар явж I010,7 тоот
өндөрлөг бүхий Зүсийн Гүний овоо /Зүс Гурван овоо/-нд хүрнэ.

13. 1010,7 тоот өндөрлөг бүхий Зүсийн Гүний овоо/Зүс Гурван овоо/-ноос эхлэн хилийн шугам нь шулуун шугамаар явж Алаг Улааны овоонд хүрч цаашаа барагцаалбал зүүн хойшоо чиглэн Хурц Хар Дэлийн Өвөр Улаан Толгойн овоо /Шар Дэл овооноос зүүн хойш 0,3 км орчимд байгаа нэг овоо/, Олстойн овоо, Аман Тооройн овоо, 993,2 тоот өндөрлөг бүхий Хар Дэлийн овоо, Цагаан Бухын овоо, Хүрэн Цавын овоо, 948,0 тоот өндөрлөг бүхий Загийн Захын овоо / Бор хушуу/, 944,4 тоот өндөрлөг бүхий Хар Толгойн овоо / 942,9 тоот өндөрлөг бүхий Хилийн Хар толгой /, 958,2 тоот өндөрлөг бүхий Сий-нэнгийн овоо, Наранбулгийн овоо/ Цагаан Овоо уул/, Ганжуур Гүний худаг, 862,8 тоот өндөрлөг бүхий Худгийн Цагаан Хушууны овоо /Шилийн Цагаан Хушуу овоо/, 906 тоот өндөрлөг бүхий Улаан Тээгийн овоо /Нуурын Гүн Улаан Тээгийн овоо/-нуудыг тус тус шулуун шугамаар дайран явж 995,4 тоот өндөрлөг бүхий Модон Овооны овоо /995,1 тоот өндөрлөг бүхий Модон овоо/-нд хүрнэ.

14. 995,4 тоот өндөрлөг бүхий Модон Овооны овоо /995,1 тоот өндөрлөг бүхий Модон овоо/-ноос эхлэн хилийн шугам нь шулуун шугамаар явж 1071,1 тоот өндөрлөг бүхий Хуц уулын өмнө зүгээс ялимгүй баруун тийш 7,8 км орчимд байгаа цэг /Бор хушууны 2 худаг/-ийг дайран цаашаа шулуун шугамаар явж 1071,1 тоот өндөрлөг бүхий Хуц уулын өмнө зүгээс ялимгүй баруун тийш 2,4 км орчимд байгаа толгойн орой / 1006,0 тоот өндөрлөг /-д хүрч цаашаа шулуун шугамаар явж Зээрд Азаргын Шинэ Цагаан Овооны овоо /Хичийн Гурван Цагаан овоо/-нд хүрч шулуун шугамаар явж 1095,2 тоот өндөрлөг /Тао Гау Гурван Зээрд Хай/-т хүрээд шулуун шугамаар явж 1072,7 тоот өндөрлөгөөс зүүн урагш 2,6 км орчимд байгаа цэг /Хөх хушуу /-ийг дайран цаашаа зүүн урагш шулуун шугамаар 2 км орчим явж тэндээс шулуун шугамаар явж 1165,8 тоот өндөрлөгөөс зүүн өмнө 1,6 км орчимд байгаа өндөрлөг /1163,1 тоот өндөрлөг /-т хүрч цаашаа шулуун шугамаар явж Довжооны ус /Довжооны хоёр худаг/-ны өмнө зүгээс ялимгүй баруун тийш 0,6 км орчимд байгаа цэгт хүрч цаашаа шулуун шугамаар явж Довжооны ус /Довжооны хоёр худаг/ -ны зүүн

зүгээс ялимгүй хойш 2,8 км орчим байгаа цэг /Шатанхай /-т хүрээд тэндээс эхлээд зүүн тийшээ 1,4 км орчим яваад дараа нь шулуун шугамаар явж Хөтөл Худгийн овоо/ 1233,8 тоот өндөрлөгөөс баруун урагш 1,7 км орчимд байгаа нэг овоо/-нд хүрч цааш шулуун шугамаар явж 1196,6 тоот өндөрлөг бүхий Бор Хушууны овоо /Шинэ Усны Хүрэн овоо /-нд хүрээд цааш шулуун шугамаар Ар Гашууны худгийг дайран 1158,9 тоот өндөрлөг /Майхан Хөх /-т хүрээд тэндээс шулуун шугамаар явж хоёр худгийн хооронд байгаа нэг цэгт хүрч барагцаалбал зүүн тийш чиглэн явж 1151,3 тоот өндөрлөг бүхий Түмэн-Өлзий овоонд хүрч цаашаа шулуун шугамаар явж 1234,0 тоот өндөрлөг бүхий Эрдэнэ овоонд хүрнэ.

15. 1234,0 тоот өндөрлөг бүхий Эрдэнэ овооноос эхлэн хилийн шугам нь шулуун шугамаар зүүн тийш явж 7,3 км орчимд байгаа өндөрлөг хүрч тэндээс шулуун шугамаар явж 1423,1 тоот өндөрлөг бүхий Сулангийн Тахилгат овоо/ 1448 тоот өндөрлөг /-ноос баруун хойш 1,1 км орчимд байгаа өндөрлөгт хүрч цааш шулуун шугамаар явж Сулангийн Тахилгат овоо /1448 тоот өндөрлөг/-нд хүрнэ. Тэндээс шулуун шугамаар явж 1403,0 тоот өндөрлөгөөс зүүн өмнө 2,95 км орчимд байгаа толгой /Их Цагаан нуруу /-д хүрээд тэндээс шулуун шугамаар явж 1334,2 тоот өндөрлөг/ Гүшэ/-өөс ялимгүй баруун урагш 2 км орчимд байгаа хижиг толгойн оройд хүрч тэндээсээ шулуун шугамаар явж 1341,8 тоот өндөрлөг бүхий Чулуун овоо /Гүшийн Баруун өмнө овоо/-нд хүрээд цааш шулуун шугамаар явж 1334,2 тоот өндөрлөг /Гүшэ/-т хүрч дараа нь шулуун шугамаар Ар Дэрсний худгийг дайран Улаан Толгойн худгаас ялимгүй баруун хойно 1,35 км орчимд байгаа цэгт хүрч тэндээсээ шулуун шугамаар 1,85 км явж Улаан Толгойн худгаас ялимгүй зүүн хойш 1,1 км-д байгаа цэг /Алгийн Хэрч/-т хүрч тэндээс шулуун шугамаар явж 1213,2 тоот өндөрлөгөөс ялимгүй зүүн хойш 1,4 км орчимд байгаа цэг/ Хар толгой/-т хүрч тэндээс шулуун шугамаар явж 1213,2 тоот өндөрлөгөөс зүүн хойш 2,6 км-д байгаа цэг/Цагаан Нуурын Дөрвөлжин Хүрэн /-т хүрээд шулуун шугамаар явж 1202 тоот өндөрлөгөөс зүүн өмнө 2,1 км орчимд байгаа Цагаан Нуурын овоо /Бумбатын овоо /-нд хүрнэ.

16. Цагаан нуурын овоо /Бумбатын овоо/-ноос эхлэн хилийн шугам нь шулуун сугамаар явж Цагаан нуур /Бумбатын Тойром/-ны дайран 1196,1 тоот өндөрлөг бүхий Дунд Шандны овоо /Дунд Дүмэ овоо/-г хүрч цаашаа шулуун сугамаар явж 1240,6 тоот өндөрлөг /1249,0 тоот өндөрлөг бүхий Гурван Баян Овоо уул /-т хүрч тэндээс шулуун сугамаар явж Нарт овоо /Нарт /-г дайрч 1328,4 тоот өндөрлөг бүхий Цар Уулын Тахилгат овоо/ 1337,2 тоот өндөрлөг бүхий Шар овоо /-нд хүрнэ. Тэндээс шулуун сугамаар явж 1221,3 тоот өндөрлөгөөс ялимгүй баруун урагш 1,9 км орчимд байгаа цэг /Нүцгэн Ухаа/ хүрч цаашаа шулуун сугамаар явж 1139,0 тоот өндөрлөгийн зүүн зүгээс ялимгүй урагш 3,8 км орчим /Зээргэнт хушуунаас зүүн хойш 0,8 км орчим/-д ердийн зам дээр байгаа цэгт хүрч тэндээс шулуун сугамаар явж 1094,4 тоот өндөрлөг бүхий Цагаан овоо /1085,0 тоот өндөрлөгийн баруун зүгээс ялимгүй урагш 0,6 км орчимд байгаа цэг/-нд хүрч цаашаа шулуун сугамаар явж 1163,5 тоот өндөрлөг бүхий Агит Хар овоо /1161,8 тоот өндөрлөг бүхий Агит овоо/-нд хүрээд тэндээс шулуун сугамаар явж 986,6 тоот өндөрлөгийн өмнө зүгээс ялимгүй зүүн тийш 3 км орчимд байгаа цэг /1042,0 тоот өндөрлөгөөс баруун тийш 0,6 км орчимд байгаа цэг/-т хүрч цаашаа шулуун сугамаар явж 1072,8 тоот өндөрлөгийн зүүн зүгээс ялимгүй урагш 2,1 км орчимд байгаа цэгт хүрч цааш шулуун сугамаар явж 1072,8 тоот өндөрлөгөөс зүүн хойш 2,8 км орчимд байгаа цэг /Хадатын овоо / хүрээд дараа нь шулуун сугамаар явж 1065,8 тоот өндөрлөгөөс зүүн өмнө 4,1 км орчимд байгаа цэг / Хадатын Булгийн Баруун Хойт овоо/ хүрч цаашаа шулуун сугамаар зүүн хойшоо чиглэн 3,2 км орчим явж 1084,3 тоот өндөрлөгөөс ялимгүй зүүн урагш 3,3 км орчимд байгаа цэг /нэргүй овоо/-т хүрч тэндээс шулуун сугамаар явж 1158,4 тоот өндөрлөг бүхий Эрдэнэцогт овоо/Талын Эрдэнэцогт/-нд хүрнэ.

17. 1158,4 тоот өндөрлөг бүхий Эрдэнэцогт овоо /Талын Эрдэнэцогт/-ноос эхлэн хилийн шугам нь барагцаалбал зүүн хойш чиглэн явж Модонгийн Шар Тойромын Баруун Хойт Талын овоо /1207,0 тоот өндөрлөгөөс зүүн хойш 1,8 км орчимд байгаа нэргүй овоо /-г дайран 1036,3 тоот өндөрлөгөөс зүүн өмнө 3,8

км-д байгаа нэргүй овоо /985,0 тоот өндөрлөг бүхий Аршаантын овоо/-нд хүрч тэндээс шулуун шугамаар явж Майхан Ухаагийн овоо/ Улаан Өндөр /-нд хүрч цааш нь шулуун шугамаар явж 982,3 тоот өндөрлөгийн зүүн зүгээс ялимгүй хойш 3,6 км-д байгаа цэг /978,7 тоот өндөрлөгөөс ялимгүй баруун хойш 2,5 км-д байгаа цэг/-т хүрээд цаашаа эхлээд зүүн зүгээс ялимгүй хойш дараа нь зүүн хойшоо чиглэн явж 967,7 тоот өндөрлөгт хүрч тэндээс шулуун шугамаар явж 954,4 тоот өндөрлөгт хүрээд тэндээсээ эхлээд хойт зүгээс ялимгүй баруун тийш чиглэн явж дараа нь баруун хойш эргэж II09,9 тоот өндөрлөг бүхий Билүүтийн Худгийн өмнө Дэлийн овоо/ Буян Бор/-нд хүрч цаашаа барагцаалбал баруун хойшоо явж I089,2 тоот өндөрлөгийн зүүн зүгээс ялимгүй урагш 3,2 км орчимд байгаа цэгээр их замын зүүн захад хүрч тэр замын зүүн захыг даган баруун хойш явж Рашаант худаг/Хөөврийн худаг/-аас баруун хойш I,4 км орчимд байгаа цэгээр замаас салж шулуун шугамаар явж III4,1 тоот өндөрлөгийг дайрч Гашуун худгийн зүүн зүгээс ялимгүй урагш 2,5 км орчимд байгаа цэгт хүрээд цаашаа барагцаалбал хойт зүгээс ялимгүй зүүн тийш чиглэн явж Хашаат худаг /I084,0 тоот өндөрлөг /ба Хар Дэлийн худгийг тус тус дайран I0I2,7 тоот өндөрлөг /Улаанцав/-т хүрч цаашаа барагцаалбал хойт зүгээс ялимгүй зүүн тийш чиглэн их замын зүүн захыг даган явж I093,2 тоот өндөрлөг/ Баян толгой/ хүрээд дараа нь замаас салж барагцаалбал зүүн зүгээс ялимгүй хойш чиглэн явж II4I,1 тоот өндөрлөгөөс зүүн өмнө 4,2 км орчимд байгаа цэг /Мааньтын Ухаагаас зүүн хойш 2 км/орчимд байгаа цэг /-т хүрч цаашаа барагцаалбал ялимгүй зүүн урагш чиглэн явж I067,6 тоот /I068 тоот / өндөрлөг бүхий Хамбын Хар дэл хүрч улмаар зүүн хойт зүгийг чиглэн явж I022,6 тоот өндөрлөг бүхий Хоонтгор хүрнэ.

18. I022,6 тоот өндөрлөг бүхий Хоонтгороос эхлэн хилийн шугам нь барагцаалбал зүүн өмнө тийшээ чиглэн явж II85,7 тоот өндөрлөг бүхий Одон Чулуу овоо/Одон Чулуу Овоо уул/ ба I3I9,7 тоот өндөрлөг/Ширгала/-ийг дайран тэндээсээ зүүн урагш явж Шаргал Шовгор /I3I6,0 тоот өндөрлөг /хүрээд тэндээсээ эхлээд барагцаалбал зүүн тийш чиглэн, дараа нь ялимгүй зүүн урагш

эргэж 1324,4 тоот өндөрлөг оүхий Арчин /1324,6 тоот өндөрлөгөөс баруун өмнө 5,2 км орчимд байгаа цэг /-г дайран цаашаа явж 1218,4 тоот өндөрлөг /1221,0 тоот өндөрлөг /-т хүрч дараа нь шулуун шугамаар явж 1314,8 тоот өндөрлөг /1315 тоот өндөрлөг /-т хүрээд цаашаа зүүн зүгээс ялимгүй урагш чиглэн явж 1296,6 тоот өндөрлөг бүхий Жаргалант Ухаа овооны баруун зүгээс ялимгүй хойш 4 км орчимд байгаа цэг / Баян хушуу / -т хүрнэ.

19. 1296,6 тоот өндөрлөг бүхий Жаргалант Ухаа овооны баруун зүгээс ялимгүй хойш 4 км орчимд байгаа цэг/ Баян хушуу /-ээс эхлэн хилийн шугам нь шулуун шугамаар явж 1222,0 тоот өндөрлөг /1119,0 тоот өндөрлөг бүхий Улаан овоо/ийг дайран Ар Модонгийн Улаан овоо/Могойт овоо/-нд хүрч дараа нь шулуун шугамаар явж 1412,0 тоот өндөрлөгөөс баруун өмнө 1,1 км орчимд байгаа нэргүй овоо /1388,0 тоот өндөрлөг /-нд хүрч цаашаа шулуун шугамаар явж 1412,0 тоот өндөрлөг /1411,0 тоот өндөрлөг/-өөс зүүн өмнө 0,4 км орчимд байгаа цэгт хүрч цаашаа шулуун шугамаар явж 1436,1 тоот өндөрлөг бүхий Бэрх Нурууны Олон овоо/ 1437 тоот өндөрлөг бүхий олон овоо/-нд хүрч барагцаалбал зүүн хойш тахиралдсан шугамаар явж 1440,7 тоот өндөрлөгийг дайрч 1500,1 тоот өндөрлөг бүхий Өндөр Мааньтын овоо /Өндөр Мааньт/-нд хүрээд тэндээс шулуун шугамаар явж 1412,1 тоот өндөрлөгөөс баруун өмнө 2,4 км орчимд байгаа цэг /1381,0 тоот өндөрлөг/-т хүрнэ. Цаашаа шулуун шугамаар явж Хангил булаг /Хангилаг булаг/-т хүрч цаашаа шулуун шугамаар явж 1484,4 тоот өндөрлөг /1488,0 тоот өндөрлөг бүхий Зэрэглээ /-т хүрч дараа нь шулуун шугамаар явж 1544,2 тоот өндөрлөгийн баруун толгойн орой /1548,0 тоот өндөрлөг бүхий Бүдүүн толгой/-д хүрээд цаашаа зүүн тийш чиглэн явж 1544,2 тоот өндөрлөг хүрээд тэндээс шулуун шугамаар явж 1576,6 тоот өндөрлөг бүхий Ачаагийн баруун зүгээс ялимгүй хойш 7 км орчимд байгаа нэргүй овоо /1525,0 тоот өндөрлөг/-нд хүрч цаашаа шулуун шугамаар явж 1476,9 тоот өндөрлөг бүхий Хөгнийн Бор толгой /Хөгнийн толгой/ хүрч дараа нь шулуун шугамаар явж Хөгнийн булгаас өмнө зүгт 0,8 км-т байгаа цэгт хүрч цаашаа шулуун шугамаар явж 1544,4 тоот өндөрлөг бүхий Шаазант /1539,0 тоот өндөрлөг бүхий

Улаан овоо/-д хүрээд цаашаа шулуун шугамаар явж 1572,2 тоот /1574,0 тоот/ өндөрлөг бүхий Ламтын Дөшид хүрнэ.

20.1572,2 тоот /1574,0 тоот/ өндөрлөг бүхий Ламтын Дөшөөс эхлэн хилийн шугам нь шулуун шугамаар хойт зүгээс ялимгүй зүүн тийш 5 км орчим, 1538,6 тоот өндөрлөг бүхий Ухаа толгой /Баруун Сиймхий/-н өмнө зүгээс ялимгүй зүүн тийш 5,5 км орчимд байгаа цэгт хүрч цаашаа шулуун шугамаар явж 1538,6 тоот өндөрлөг бүхий Ухаа толгой /Баруун Сиймхий/-гоос зүүн зүгээс ялимгүй хойш 2,5 км орчимд байгаа цэгт хүрээд дараа нь мөн шулуун шугамаар явж 1524,4 тоот өндөрлөг бүхий Сиймхийгээс ялимгүй зүүн хойш 1,3 км орчимд байгаа цэг /1469,0 тоот өндөрлөг бүхий Талын Ухаа овоо/-т хүрч тэндээс шулуун шугамаар явж 1567,1 тоот өндөрлөг бүхий Ягаан толгойд хүрч цаашаа шулуун шугамаар явж 1599,5 тоот өндөрлөг бүхий Сэнжитийн өндөр /Сэнжитийн Хар өндөр/-ийн өмнө зүгээс ялимгүй зүүн тийш 1,7 км-д байгаа жижиг толгойд хүрч цаашаа зүүн урагш чиглэн явж 1507,0 тоот өндөрлөг бүхий Баян Өргөний өмнө зүгээс ялимгүй зүүн тийш 1,3 км орчимд байгаа жижиг уулын орой /1461,0 тоот өндөрлөг/-т хүрч цаашаа шулуун шугамаар явж 1460,1 тоот өндөрлөгөөс баруун өмнө 2,5 км орчимд байгаа жижиг уулын орой /1442,0 тоот өндөрлөг/-д хүрээд дараа нь барагцаалбал зүүн тийш чиглэн явж 1510,5 тоот өндөрлөгт хүрч цаашаа шулуун шугамаар явж 1600,1 тоот өндөрлөгөөс ялимгүй зүүн урагш 4,1 км орчимд байгаа жижиг уулын орой /1433,0 тоот өндөрлөг бүхий Тайжийн овоо/-д хүрч мөн шулуун шугамаар явж 1335,7 тоот өндөрлөг бүхий Зүүн Баян Мэнд /1336,0 тоот өндөрлөг бүхий Удган дэл/хүрч цаашаа шулуун шугамаар явж 1289,5 тоот өндөрлөг бүхий Баруун Холбоо Улаан /1290,0 тоот өндөрлөг бүхий Холбоо толгой/-д хүрч мөн шулуун шугамаар явж 1462,2 тоот өндөрлөг бүхий Баруун Могнон /1464,0 тоот өндөрлөг бүхий Баруун Манатур/-д хүрнэ.Цаашаа шулуун шугамаар явж 1291,9 тоот /1292,4 тоот/ өндөрлөг хүрээд шулуун шугамаар явж 1280,2 тоот өндөрлөг бүхий Дүмбэн /Сүйх Цагаан/-д хүрч цаашаа барагцаалбал эхлээд зүүн хойшоо чиглэн, дараа нь ялимгүй зүүн хойш эргэн яваад 1189,8 тоот өндөрлөгийн өмнө зүгээс ялимгүй баруун тийш 1 км

орчимд байгаа цэгт хүрээд зүүн тийшээ тахиралдан явж 1232 тоот өндөрлөг бүхий Лачинвандад уул /Ламхайн овоо /-д хүрнэ.

21. 1232 тоот өндөрлөг бүхий Лачинвандад /Ламхайн овоо/ уулаас эхлэн хилийн шугам нь эхлээд ялимгүй зүүн хойш тохойрон дараа нь зүүн хойш эргэж гурван нэргүй толгойг дайрч яваад 980,1 тоот өндөрлөг/Шар Өндөр/-т хүрч цаашаа зүүн хойш явж 928,3 тоот өндөрлөг бүхий Бичигт толгойд хүрч зүүн тийш шулуун шугамаар явж 1,6 км орчимд байгаа цэгт хүрч тэндээс барагцаалбал хойт зүгээс ялимгүй баруун тийш чиглэн эхлээд шулуун шугамаар 6,8 км орчим явж дараа нь тахиралдсан шугамаар явж 910,2 тоот өндөрлөг бүхий Уушигийн Улаанаас зүүн тийш 3 км орчимд байгаа цэгт хүрээд цаашаа барагцаалбал ялимгүй зүүн хойш явж 763,9 тоот өндөрлөгийн зүүн зүгээс ялимгүй урагш 2 км орчимд байгаа цэгт хүрээд дараа нь шулуун шугамаар явж 790,3 тоот өндөрлөгт хүрч дараа нь шулуун шугамаар явж Талын Манхан /Улаан Орвоо/-д хүрээд мөн шулуун шугамаар явж Ганцон Шүү нуураас баруун урагш 1 км орчимд байгаа цэгт хүрч дараа нь шулуун шугамаар явж Ганцын Шүү нуурын дундуур гарч мөн нуураас зүүн хойш 1,1 км орчимд байгаа цэгт хүрээд цаашаа шулуун шугамаар явж нэргүй жижиг нуур /884,7 тоот өндөрлөгөөс ялимгүй баруун урагш 4,8 км орчимд байгаа жижиг нуур /-ын баруун эрэгт хүрч тэндээс шулуун шугамаар зүүн тийш нуурыг хөндлөн гарч цаашаа шулуун шугамаар явж Баруун Шар Ухаа /Баян Модны Цагаан толгой/-гаас баруун хойш 1,5 км орчимд байгаа цэгт хүрнэ. Цаашаа эхлээд хойт зүгээс ялимгүй баруун тийш, дараа нь зүүн хойш тохойрон эргэж Дунд Ухаад хүрээд ялимгүй зүүн урагш тохойрон уулыг хярлан явж 978,4 тоот өндөрлөг бүхий Зүүн Боролж /Хамгатын Бүдүүн /-д хүрнэ. Цааш шулуун шугамаар явж 952,9 тоот өндөрлөг /Их Хадат/-еос баруун тийш 5,6 км орчимд байгаа нуурын хойт талаар гарч Даваажавын Манхан /нэг элсэн манхан/-н өмнө талд байгаа нэг цэгт хүрч цаашаа шулуун шугамаар явж 952,9 тоот өндөрлөг /Их Хадат /-т хүрнэ. Цаашаа шулуун шугамаар явж Гүн Манханаас хойш монголын хилийн цэргийн Их Айлын

заставын байрны урьд талаар гарч шулуун шугамаар явж 906,8 тоот өндөрлөг /Хөвдөн толгой/-өөс зүүн өмнө 4,4 км орчимд байгаа толгойн оройд хүрч цаашаа хойт зүгээс ялимгүй зүүн тийш чиглэн явж 894,4 тоот өндөрлөгөөс зүүн урагш 2 км орчимд байгаа уулын орой /Бага Нүхт/; 881,6 тоот өндөрлөгөөс зүүн урагш 1,7 км орчимд байгаа уулын орой /Их Нүхт/; 869,6 тоот өндөрлөг; 886,3 тоот өндөрлөг /Дулага добог/-үүдийг тус тус дамжин цаашаа шулуун шугамаар явж 938 тоот өндөрлөгт хүрнэ.

22. 938 тоот өндөрлөгөөс эхлэн хилийн шугам нь барагцаалбал зүүн зүгээс ялимгүй хойш тахиралдсан шугамаар явж 942,2 тоот өндөрлөгт хүрч ялимгүй зүүн урагш чиглэн уулын хяраар явж 961,8 тоот өндөрлөг /Онъ Хөтөл/-ийг дайран 986,6 тоот өндөрлөг /Урт Гууны Эх/ хүрч цаашаа уулын хяраар тахиралдсан шугамаар зүүн хойш явж 963,9 тоот өндөрлөгийг дайран 1004,7 тоот өндөрлөг /Шарниг/-т хүрч тэндээс зүүн хойшоо тахиралдсан шугамаар явж 934,0 тоот өндөрлөг ба 967,2 тоот өндөрлөгөөс зүүн өмнө 0,9 км орчимд байгаа жижиг уулын оройг дайран 1112,0 тоот өндөрлөг бүхий Хулд уулаас ялимгүй зүүн урагш 0,8 км орчимд байгаа жижиг уулын оройд хүрч, цаашаа ялимгүй зүүн хойш тохойрон явж 1017,5 тоот өндөрлөгийн зүүн зүгээс ялимгүй урагш 2,3 км орчимд байгаа цэгт хүрээд барагцаалбал ялимгүй зүүн урагш явж 927,4 тоот өндөрлөгт хүрээд цаашаа шулуун шугамаар явж 932 тоот өндөрлөг бүхий Тосон толгой/Шар Энгэр/ хүрч мөн шулуун шугамаар явж 845,5 тоот өндөрлөг /Эрэмт/-т хүрнэ. Цаашаа эхлээд зүүн хойш, дараа нь ялимгүй зүүн урагш тахиралдсан шугамаар явж 945,6 тоот өндөрлөгт хүрч цаашаа явж 1014,0 тоот өндөрлөгийн баруун зүгээс ялимгүй урагш 1,5 км орчимд байгаа уулын орой /Дун Цагаан/-д хүрч дараа нь 1034,5 тоот өндөрлөгийн баруун зүгээс ялимгүй урагш 0,9 км орчимд байгаа жижиг уулын оройд хүрч дараа нь баруун хойшоо уулын хяраар явж 969,8 тоот өндөрлөгт хүрээд цаашаа барагцаалбал зүүн хойш явж 1047,9 тоот өндөрлөгийг дайран 1096,3 тоот өндөрлөг бүхий Намжил уул/Шапа уул/ хүрээд цаашаа эхлээд ялимгүй зүүн хойш, дараа нь зүүн урагш явж 1123,0 тоот

өндөрлөгт хүрч цаашаа өмнө зүгээс ялимгүй зүүн тийш уулын хяраар явж III4,2 тоот өндөрлөгөөс хойт зүгт I,3 км орчимд байгаа уулын оройд хүрнэ. Цаашаа зүүн хойш тахиралдсан шугамаар явж I030,7 тоот өндөрлөгт хүрч тэндээсээ барагцаалбал зүүн урагш явж I089,0 тоот өндөрлөгт хүрч цаашаа уулын хяраар явж II42,7 ба II85,4 тоот өндөрлөгүүдийг тахиралдсан шугамаар дайран явж Буян гол /Тогай гол/ ба өмнө талаас цутгасан нэг салаа голын билчирт хүрнэ.

23. Буян гол /Тогай гол/ ба өмнө талаас цутгасан нэг салаа голын билчрээс эхлэн хилийн шугам нь шулуун шугамаар явж IIII,2 тоот өндөрлөгт хүрч цаашаа шулуун шугамаар явж I082,6 тоот өндөрлөгт хүрээд тэндээсээ шулуун шугамаар зүүн тийш 3,1 км орчим явж нэргүй уулын оройд хүрч цаашаа эхлээд зүүн урагшаа, дараа нь зүүн зүгээс ялимгүй хойш чиглэн уулыг хярлан явж I309,5 тоот өндөрлөгт хүрч цаашаа Гуут голыг огтлон гарч I3I9,6 тоот өндөрлөгт хүрээд Гуут гол ба Галдастайн /Нарийн гол/ голын хоорондох уулын ус хуваагч шугамаар зүүн урагш явж I400,1 тоот өндөрлөг /Ухаатын овоо/-ийг дайран I470 тоот өндөрлөг бүхий Өндөр Оройн овоо/I470,8 тоот өндөрлөг/-ноос зүүн хойш I,9 км орчимд байгаа уулын оройд хүрч цаашаа нэг талаас Галдастайн гол/ Нарийн гол/, Бүрийн голын баруун салаа/Дөрөвдүгээр Бүрийн Таван салаа гол/, нөгөө талаас Өргөн голуудын хоорондох уулын ус хуваагч шугамаар явж I377 тоот өндөрлөг бүхий Модон Замын Цагаан Давааны овоо/Халзан Оройн овоо/; I492,4 тоот өндөрлөг бүхий Баян Хээр уул /Халзан орой/-ыг тус тус дайран I503,0 тоот өндөрлөг бүхий Соёлз уул /Богд уул/-ын оройд хүрнэ.

24. I503,0 тоот өндөрлөг бүхий Соёлз уул /Богд уул/-ын оройгоос эхлэн хилийн шугам нь уулыг хярлан ялимгүй зүүн хойш уруудаж хоёр замын уулзвар хүрч цаашаа хойш явсан замын дагуу явж хоёр замын салах цэгт хүрч дараа нь зүүн талын замаар явж I309,6 тоот өндөрлөгөөс баруун хойш 2,4 км орчимд байгаа цэгт хүрээд замаас салж баруун хойш явж нэргүй голын усаар уруудаж мөн гол ба Бүрийн голын зүүн салаа /хоёрдугаар Бүрийн Таван салаа/ голын билчирт хүрч мөн голын усаар уруудаж их замын гарам хүрээд тэндээс хойшоо явсан их замаар тахирлан явж Нөмрөг голын Хорчин олом /гарам/-оор гарч

тэндээс баруун зүгээс ялимгүй хойш шулуун шугамаар 0,3 км орчим явж цаашаа баруун хойш мөн шулуун шугамаар 1,4 км орчим явж 1242 тоот өндөрлөгөөс баруун урагш 2 км орчимд байгаа нэг овоо /Нөмрөгийн овоо/ хүрээд тэндээс шулуун шугамаар явж 1232,9 тоот өндөрлөг хүрч цаашаа шулуун шугамаар явж 1280,4 тоот өндөрлөг хүрч мөн шулуун шугамаар явж 1228,6 тоот өндөрлөгт хүрнэ.

25. 1228,6 тоот өндөрлөгөөс эхлэн хилийн шугам нь хойт зүгээс ялимгүй баруун тийш чиглэн явж нэргүй голд хүрч мөн голын усаар өгсөж 1249,6 тоот өндөрлөгөөс зүүн хойш 1,3 км орчимд байгаа цэгт хүрч голоосоо салж барагцаалбал баруун хойшоо чиглэн явж 1213,7 тоот өндөрлөгөөс зүүн хойш 1,7 км орчимд байгаа газраар Нарийн голыг хөндлөн гарч цаашаа хойт зүгээс ялимгүй зүүн тийш тахирлан явж Амралт Уулавд хүрээд цаашаа шулуун шугамаар явж Нагат уул хүрээд дараа нь шулуун шугамаар явж Хадат уул хүрнэ. Цаашаа шулуун шугамаар явж 1174,8 тоот өндөрлөгөөс зүүн хойш 1,4 км орчимд байгаа цэгээр Хужиртын голд хүрч цаашаа Хужиртын голын усаар уруудаж мөн гол ба Нөмрөгийн голын билчирт хүрээд цаашаа Нөмрөгийн голын усаар уруудан мөн гол ба Халхын голын билчирт хүрээд Халхын голын усаар уруудаж 877,8 тоот өндөрлөгөөс ялимгүй баруун хойш 3,1 км орчимд байгаа цэгээр голоосоо салж тэндээсээ ялимгүй зүүн хойш чиглэн явж 1013,5 тоот өндөрлөг бүхий Баруун Өндөрөөс зүүн урагш 3,35 км орчимд байгаа толгойн орой /Хараат уулын овоо/ хүрч дараа нь шулуун шугамаар явж 988,9 тоот өндөрлөгөөс зүүн тийш 0,6 км орчимд байгаа жижиг уулын оройд хүрнэ. Цаашаа шулуун шугамаар явж 899,7 тоот өндөрлөгөөс зүүн хойш 1,2 км орчимд байгаа цэг / Эрс уулын овоо/ хүрч тэндээс шулуун шугамаар явж 973,0 тоот өндөрлөг бүхий Хулд уул / Дархан уул/ -д хүрч цаашаа шулуун шугамаар явж 761,2 тоот өндөрлөг бүхий Өндөр Улааны зүүн зүгээс ялимгүй хойш 4,5 км орчимд байгаа цэг / Номон Хаан Бүрд овоо/ хүрээд цаашаа шулуун шугамаар явж Шилийн худгийн овоо / Шилийн худгаас зүүн өмнө 0,1 км-д байгаа нэг овоо/ хүрнэ. Цаашаа шулуун шугамаар явж 706,2 тоот өндөрлөгийг дайран Халхын голд хүрч Халхын голын усаар уруудаж

мен гол ба Шарилжийн голын салах газарт хүрээд цаашаа Шарилжийн голыг уруудаж мөн голын хойт эрэг дээр байгаа 589,0 тоот өндөрлөгөөс баруун тийш 0,2 км орчимд байгаа цэгээр голоосоо салж цаашаа шулуун сугамаар явж Оршуун голыг гаталж гараад мөн голын баруун эрэг дээр байгаа 591,2 тоот өндөрлөг бүхий Улаан Гангын овоо /Мухар овоо/-д хүрч цаашаа шулуун сугамаар баруун урагш явж 585,9 тоот өндөрлөгөөс баруун тийш 2,65 км орчимд байгаа цэгээр Буйр нуурын эрэгт хүрч тэндээсээ Буйр нуурыг огтолож 585,9 тоот өндөрлөгөөс зүүн хойш 0,95 км орчимд байгаа цэгээр Буйр нуурын эрэгт хүрээд тэндээс шулуун сугамаар баруун урагш 1,2 км явж 585,9 тоот өндөрлөгийн баруун зүгээс ялимгүй хойш 0,5 км орчимд байгаа цэгт хүрч цаашаа шулуун сугамаар явж 602,0 тоот өндөрлөгөөс ялимгүй зүүн урагш 3,9 км орчимд байгаа цэг/ Шилийн Овооны хонхор/-т хүрнэ.

26. 602,0 тоот өндөрлөгөөс ялимгүй зүүн урагш 3,9 км орчимд байгаа цэг /Шилийн Овооны хонхор/-ээс эхлэн хилийн шугам нь шулуун сугамаар явж Модон Хашаатын Модон Тэмдэгт /616,2 тоот өндөрлөгийн хойт зүгээс ялимгүй зүүн тийш 2 км орчимд байгаа цэг/-д хүрч цаашаа шулуун сугамаар явж 598,4 тоот өндөрлөг бүхий Ар Булгийн Модон тэмдэг / Ар Дүлийн Модон тэмдэг /-т хүрч тэндээс эхлээд баруунаас ялимгүй хойгуур, дараа нь баруунаас ялимгүй урдуур шулуун сугамаар явж 633,6 тоот өндөрлөгөөс зүүн урагш 2,9 км орчимд байгаа цэгт хүрч, дараа нь шулуун сугамаар явж 571,5 тоот өндөрлөгөөс ялимгүй зүүн урагш 2,4 км орчимд байгаа цэгт хүрнэ. Цаашаа шулуун сугамаар явж Ар Булгийн хоёр худаг/ Хул Дэрс худаг /-ийн дундуур гарч тэндээс шулуун сугамаар явж 634,0 тоот өндөрлөгт хүрч цаашаа шулуун сугамаар явж 622,6 тоот өндөрлөгт хүрээд мөн шулуун сугамаар явж 627,0 тоот өндөрлөг бүхий Еэнчийн овоо/ Енчин/-нд хүрч тэндээс шулуун сугамаар явж 698,2 тоот өндөрлөг /Хашаат овоо/-т хүрээд дараа нь шулуун сугамаар явж 667,3 тоот өндөрлөгөөс зүүн хойш 2,4 км орчимд байгаа цэгээр Хэрлэн голд хүрч тэндээс Хэрлэн голын усаар өгсөж Хорхойтын булгаас баруун өмнө

1,15 км орчимд байгаа цэгээр голоосоо салж шулуун шугамаар явж 641,8 тоот өндөрлөг бүхий Өндгөгийн Тохой/ Хорхойтын овоо/-д хүрнэ. Тэндээс шулуун шугамаар явж 764,7 тоот өндөрлөг бүхий Бүрхээрийн овоо/ Бүрхээр уул/ хүрч цаашаа шулуун шугамаар явж 827,8 тоот өндөрлөг бүхий Зараагийн овоо / Зараа уул/ хүрээд дараа нь шулуун шугамаар явж 862,9 тоот өндөрлөг бүхий Хавцгайтын овоо /Харуулын овоо /хүрнэ.Цаашаа шулуун шугамаар явж 810,8 тоот өндөрлөг бүхий Шаварт булгийн овоо /Шаварт овоо/ хүрч тэндээс шулуун шугамаар явж 721,5 тоот өндөрлөг; 864,2 тоот өндөрлөг бүхий Чонот уул /Их Нарст уул/; 775,0 тоот өндөрлөгүүдийг тус тус шулуун шугамаар дайрч 764,3 тоот өндөрлөг бүхий Ширчиний оргил /Ширийн овоо/ хүрч дараа нь шулуун шугамаар явж Тарган цагаан нуур/ Тарган нуур/-аас зүүн хойно байгаа хятад, монголын хилийн шугамын зүүн үзүүрийн эцсийн цэг болох 645,0 тоот өндөрлөг бүхий Тарваган Дахын овоо /645,5 тоот өндөрлөг/-нд хүрнэ.

Энэ зүйлд дурдсан хоёр улсын хилийн нийт шугамыг хятад, монгол хал дээр үйлдсэн бөгөөд энэхүү Гэрээнд хавсаргагдсан 1:1 000 000 масштабын газрын зурагт тэмдэглэн тодорхойлов.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Гэрээ байгуулагч Талууд тохиролцсон нь:

1. Голын урсгалаар хоёр улсын хил болгосон хэсэг газарт хилийн шугам нь уг голын үндсэн урсгалын савын төв дундуур байх болно. Хэрэв ийнхүү хил болгосон голын үндсэн урсгалын сав өөрчлөгдвөл хоёр Тал жич зөвлөлдөн хэлэлцэж шийдвэрлэх хүртэл хилийн шугам өөрчлөгдөхгүй байх болно.

Урсгалаар нь хил болгосон голын усыг хоёр Тал хамтран ашиглах бөгөөд голын усыг ашиглах журмыг хоёр Талын зохих байгууллагууд жич хэлэлцэн тогтооно.

2. Хил болгосон голуудад байгаа арал, сайруудыг Хятадын талын эрэгт ойр байгаа бол Хятадын талд, Монголын талын эрэгт ойр байгаа бол Монголын талд хамааруулна. Голын үндсэн урсгалын савын төв дунд байгаа арал, сайруудыг аль талд хамааруулахыг хоёр Тал зөвлөлдөн хэлэлцэж шийдвэрлэнэ. Хилийн

шугамыг газар дээр тогтоон тэмдэглэсний дараа шинээр арал ба сайр тогтвол энэхүү зарчмыг баримтлан шийдвэрлэнэ.

3. Хоёр улсын хилийн шугам дээр байгаа худаг,булгийг хоёр Талын хамтын мэдэлд байлган, хамтран арчилж , хамтран ашиглах болно. Худаг,булгийг хамтран арчлах,ашиглах журмыг хоёр Талын зохих байгууллагууд жич хэлэлцэн тогтооно.

4. Хоёр улсын хил болгосон замыг хоёр Талын хамтын мэдэлд байлган, хамтран арчилж, хамтран ашиглах болно. Хил болгосон замыг хамтран арчлах ба хамтран ашиглах журмыг хоёр Талын зохих байгууллагууд жич хэлэлцэн тогтооно.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Гэрээ байгуулагч Талууд тохиролцсон нь:

1. Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болмогц хилийн шугамыг газар дээр тогтоон тэмдэглэх Хятад, Монголын хамтарсан комиссыг байгуулж, энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд заасан хоёр улсын хилийн бүх шугамыг газар дээр нь тогтоон,хилийн тэмдгүүдийг босгох,мөн хилийн бүх шугамын байршилтын зүг чиг, хилийн тэмдгүүдийн байрлалтыг нарийвчлан тодорхой бичсэн хоёр улсын хилийн тухай протоколыг төлөвлөн боловсруулах бөгөөд хилийн газрын зургийг зурж үйлдэнэ.

2. Энэхүү зүйлийн нэгд дурдсан протокол,хилийн газрын зургууд нь хоёр улсын Засгийн Газрын төлөөлөгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж энэхүү Гэрээний хавсралт болно. Хилийн шугамыг газар дээр тогтоон тэмдэглэх Хятад,Монголын хамтарсан комиссын үйлдсэн хилийн газрын зураг нь энэхүү Гэрээний хавсралт газрын зургийг төлөөлөх болно.

3. Дээр дурдсан протокол ба хилийн газрын зурагт гарын үсэг зурмагц хилийн шугамыг газар дээр тогтоон тэмдэглэх Хятад,Монголын хамтарсан комиссын ажил дуусгавар болно.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Гэрээг хоёр талаас батлах бөгөөд батламж бичгийг аль болох ойрын хугацаанд Улаанбаатар хотноо солилцоно.

Энэхүү Гэрээ нь батламж бичгийг солилцсон өдрөөс

эхлэн хүчин төгөлдөр болно.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газрын төлөөлөгчдийн 1962 оны II дүгээр сарын 17-ны өдөр гарын үсэг зурсан хэлэлцээний протоколоос бусад энэ Гэрээ байгуулагдахаас өмнөх үеийн тус хоёр улсын хилийн холбогдолтой баримт бичгүүд ба түүнд хавсаргагдсан газрын зургууд нь энэхүү Гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүйд тооцогдоно.

Энэхүү Гэрээг 1962 оны 12 дугаар сарын 26 ны өдөр Бээжин хотноо хятад, монгол хэл дээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд хоёр эх нь адил тэгш хүчинтэй болно.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД
АРД УЛСЫН ДАРГААС ЭРХ
ОЛГОСНООР

周恩来

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДЭЭС
ЭРХ ОЛГОСНООР

